



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/066-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:<a href="mailto:tsetsegsurena@audit.gov.mn">tsetsegsurena@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:munkhtulgad@audit.gov.mn">munkhtulgad@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.25 № 2/68

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
С.ДОЛГОРМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 8.9.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй хугацаа хоцроосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан,
- Албан хаагчдын цалингийн шатлалыг зөрүүтэй тооцон цалин илүү олгосон, өөс тэжээлийн үнийг байгууллагын төсөөт төвлөрүүлээгүй,
- Тайлант онд худалдан авсан шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, жолоочийн тооцоо бодоогүй,
- Бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй, тооцоог бодоогүй,
- Байгууллагын санхүүгийн баримтад зарлагын ажил гүйлгээний анхан шатны баримтуудыг эх хувиар нь хавсаргаагүй, сар бүрийн цагийн бүртгэл, цалингийн тооцооны хүснэгт, анхан шатны баримтгүй цалингийн ажил гүйлгээ гаргасан,

- Шилэн дансны хуульд заасан мэдээлэл, сумын ойн хандивын орлого, зарцуулалтын тайлангийн мэдээллийг мэдээлээгүй,
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд байна

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулалд 44.5 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 85.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ. Тайлант онд сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 435.3 сая төгрөгийн хандивын орлого бүрдүүлжээ.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ойн хандив, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүйгээр 1,451.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 6.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч бүртгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 7 зорилт 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.ВОЛДБААТАР



## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>109,978,028.74</u></b>	<b><u>252,479,073.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	44,869,940.74	128,788,319.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,439,580.79
33300	Татаас, санхүүжилтийн авлага	42,845,000.74	125,323,798.74
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,024,940	2,024,940
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,024,940	2,024,940
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,108,088	123,690,754
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,474,088	112,056,754
35410	Бичиг хэргийн материал	379,500	1,150,000
35420	Аж ахуйн материал	19,772,088	76,534,354
35440	Түлш, шатах тослох материал	146,000	-
35460	Хүнсний материал	22,500	-
35470	Бусад хангамжийн материал	33,154,000	34,372,400
35600	Мал амьтад	11,634,000	11,634,000
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,013,930,271.86</u></b>	<b><u>5,229,103,117.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,013,930,271.86	5,229,103,117.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,009,570,896.86	5,225,103,117.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,169,911,002	3,019,496,302
39202	Хуримтлагдсан элэгдэл	(676,716,258.38)	(753,306,306.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138,262,460	228,462,460
39204	Хуримтлагдсан элэгдэл	(122,741,631.26)	(115,329,126.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,849,607	282,599,607
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,983,063.32)	(149,213,588.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,664,182	126,013,002
39208	Хуримтлагдсан элэгдэл	(54,099,896.15)	(61,866,877.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,547,513,989	2,775,034,189
39210	Хуримтлагдсан элэгдэл	(314,033,244.03)	(409,281,193.71)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	77,831,000	281,381,900
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,081,850	1,081,850
39217	Ном	30,900	30,900
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,359,375	4,000,000
39301	Программ хангамж	3,193,700	3,193,700
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,834,325)	(3,193,700)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,000,000	4,000,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,123,908,300.60</u></b>	<b><u>5,481,582,190.57</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>452,300</u></b>	<b><u>75,754,106.85</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	452,300	75,754,106.85
<b>413</b>	<b>Өглөг</b>	452,300	75,754,106.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	8,917,003.85
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	452,300	66,837,103
41361	Байгууллагад төлөх өглөг	452,300	66,837,103
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,123,456,000.60</u></b>	<b><u>5,405,828,083.72</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,123,456,000.60	5,405,828,083.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,034,383,684	1,034,383,684

51101	Өмч: - төрийн	1,034,383,684	1,034,383,684
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,510,649,940.56</b>	<b>3,793,022,023.68</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,510,649,940.56	2,510,649,940.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,282,372,083.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	578,422,376.04	578,422,376.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,123,908,300.60</b>	<b>5,481,582,190.57</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,119,106,203</b>	<b>3,014,766,652</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>384,528,680</b>	<b>1,930,885,701</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	384,528,680	1,495,549,588
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	384,528,680	1,495,549,588
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,305,380	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,800,000	12,059,968
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	378,423,300	1,483,489,620
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	435,336,113
122001	Хандив тусламж /дотоод/	-	435,336,113
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>734,577,523</b>	<b>1,083,880,951</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	124,912,823	113,623,051
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,020,612	75,347,748
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,892,211	38,275,303
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	609,664,700	970,257,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	609,664,700	970,257,900
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>946,955,613.70</b>	<b>1,732,394,568.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>946,955,613.70</b>	<b>1,732,394,568.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	933,981,605.62	1,663,666,317.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	394,291,150.90	651,116,672.85
210101	Үндсэн цалин	301,602,742.14	431,743,407.35
210102	Нэмэгдэл	72,017,840.81	164,461,495.50
210104	Урамшуулал	2,520,447.95	54,366,080
210105	Гэрээт ажлын хөлс	18,150,120	545,690
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,375,358.25	81,642,007.80
210201	Тэтгэврийн даатгал	36,252,013.70	55,186,333.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,280,137.09	6,505,709.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,629,609.89	3,793,080.11
210204	Ажилгүйдлийн даатгал	653,323.31	3,246,254.94
210205	Эрүүл мэндийн даатгал	6,560,274.26	12,910,629.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62,172,066.77	72,936,102.00
210301	Гэрэл, цахилгаан	17,768,286.77	15,056,800.00
210302	Түлш, халаалт	36,277,090	46,201,002
210303	Цэвэр, бохир ус	8,126,690	11,678,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	85,661,302	113,164,804.36
210401	Бичиг хэрэг	8,602,000	20,380,000
210402	Тээвэр, шатахуун	41,867,970	83,464,804.36

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,937,800	3,125,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,194,400
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,253,532	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>397,800</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	397,800	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,766,759</b>	<b>32,802,000</b>
210604	Урсгал засвар	5,766,759	32,802,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,741,932</b>	<b>16,419,800</b>
210702	Дотоод албан томилолт	11,741,932	16,419,800
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>86,897,662</b>	<b>31,434,367</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,994,662	29,803,967
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	24,000	311,400
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000	285,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	34,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	537,000	1,000,000
210807	Газрын төлбөр	102,000	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>237,677,574.70</b>	<b>664,150,563.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,584,125	411,316,189
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	578,000	10,052,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	202,515,449.70	242,782,374.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,974,008.08</b>	<b>67,053,751.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>190,000</b>	<b>46,276,500</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	44,502,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,000	1,774,500
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>12,784,008.08</b>	<b>22,451,751.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,784,008.08	22,451,751.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>172,150,589.30</u></b>	<b><u>1,282,372,083.12</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>172,150,589.30</u></b>	<b><u>1,282,372,083.12</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>768,928,964.74</u></b>	<b><u>1,626,583,135.74</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,105,380</b>	<b>542,702,184.74</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,105,380	107,366,071.74
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,105,380	64,521,071
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,305,380	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,800,000	64,521,071
120009	Бусад орлого	-	42,845,000.74
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	435,336,113
122001	Хандив тусламж /дотоод/	-	435,336,113
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>762,823,584.74</b>	<b>1,083,880,951</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	153,158,884.74	113,623,051
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,020,612	75,347,748

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,138,272.74	38,275,303
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	609,664,700	970,257,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	609,664,700	970,257,900
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>768,928,964.74</b>	<b>1,622,957,135.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>768,928,964.74</b>	<b>1,622,957,135.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>711,525,455.92</b>	<b>1,428,905,085.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	394,199,225.93	644,299,959.30
210101	Үндсэн цалин	267,489,270.49	382,207,194.54
210102	Нэмэгдэл	80,899,250.81	207,395,901.68
210104	Урамшуулал	22,112,630.82	45,992,224.53
210105	Гэрээт ажлын хөлс	23,698,073.81	8,704,638.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,467,283.22	80,981,298.29
210201	Тэтгэврийн даатгал	34,404,205.30	55,051,700
210202	Тэтгэмжийн даатгал	3,974,323.54	6,475,500
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,085,057.17	3,829,700
210204	Ажилгүйдлийн даатгал	657,223.31	2,686,498.65
210205	Эрүүл мэндийн даатгал	7,346,473.90	12,937,899.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62,172,066.77	73,281,102
210301	Гэрэл, цахилгаан	17,768,286.77	15,056,800
210302	Түлш, халаалт	36,277,090	46,546,002
210303	Цэвэр, бохир ус	8,126,690	11,678,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,134,092	156,739,869
210401	Бичиг хэрэг	5,815,300	96,565,280
210402	Тээвэр, шатахуун	27,380,992	56,795,289
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,937,800	3,379,300
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	503,900	553,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	503,900	553,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,182,984	91,661,700
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280,600	317,000
210604	Урсгал засвар	8,902,384	91,344,700
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,741,932	16,419,800
210702	Дотоод албан томилолт	11,741,932	16,419,800
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	100,664,662	114,185,822.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,761,662	112,637,422.36
210803	Даатгалын үйлчилгээ	24,000	311,400
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000	285,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	34,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	537,000	918,000
210807	Газрын төлбөр	102,000	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,459,310	250,781,835
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,759,310	197,681,035
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000	53,100,800
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,403,508.82</b>	<b>194,052,049.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,774,500.00	46,276,500.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	44,502,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,774,500	1,774,500
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	55,629,008.82	22,451,751.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,629,008.82	22,451,751.05
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	125,323,798.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		125,323,798.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b><u>3,626,000</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>3,626,000</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,626,000</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	3,626,000
222001	Тоног төхөөрөмж	-	3,626,000
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b><u>(3,626,000)</u></b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	2,181,144,402.15	3,793,950,462.19
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	2,181,144,402.15	3,793,950,462.19
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	329,505,538.41	157,354,949.11
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	2,510,649,940.56	4,123,456,000.60
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	2,510,649,940.56	4,123,456,000.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	2,510,649,940.56	4,123,456,000.60
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,282,372,083.12	1,282,372,083.12
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684	578,422,376.04	3,793,022,023.68	5,405,828,083.72

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	980,862,900	959,866,116.95
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	980,862,900	959,866,116.95
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	929,486,400	909,963,616.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	647,571,800	643,639,959.30
210101	Үндсэн цалин	359,708,700	382,207,194.54
210102	Нэмэгдэл	239,171,400	207,395,901.68
210104	Урамшуулал	17,011,700	45,992,224.53
210105	Гэрээт ажлын хөлс	31,680,000	8,044,638.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80,946,500	80,898,798.29
210201	Тэтгэврийн даатгал	55,043,600	54,969,200
210202	Тэтгэмжийн даатгал	6,475,700	6,475,500
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,798,400	3,829,700
210204	Ажилгүйдлийн даатгал	1,677,400	2,686,498.65
210205	Эрүүл мэндийн даатгал	12,951,400	12,937,899.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	77,353,100	72,281,102
210301	Гэрэл, цахилгаан	14,056,800	14,056,800
210302	Түлш, халаалт	51,618,000	46,546,002
210303	Цэвэр, бохир ус	11,678,300	11,678,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,435,100	28,435,100
210401	Бичиг хэрэг	2,712,200	2,712,200
210402	Тээвэр, шатахуун	22,343,600	22,343,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,379,300	3,379,300
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	553,700	553,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700	553,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,790,700	2,789,800
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000	317,000
210604	Урсгал засвар	2,473,700	2,472,800
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	16,419,800	16,419,800
210702	Дотоод албан томилолт	16,419,800	16,419,800
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,240,100	17,437,807.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,349,600	15,889,407.36
210803	Даатгалын үйлчилгээ	346,000	311,400
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,000	285,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,000	34,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,000	918,000
210807	Газрын төлбөр	307,500	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	56,175,600	47,507,550
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,691,600	46,101,750
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000	1,405,800
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	46,276,500	46,276,500
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	46,276,500	46,276,500
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000	44,502,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,774,500	1,774,500
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,100,000</b>	<b>3,626,000</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,100,000	3,626,000
222001	Тоног төхөөрөмж	5,100,000	3,626,000

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	980,862,900	959,866,116.95
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	970,257,900	947,806,148.95
132001	Орон нутгийн төсвөөс	970,257,900	947,806,148.95
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,605,000	12,059,968
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,605,000	12,059,968
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	28	26
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	8
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	5	5
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28</b>	<b>26</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	6
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9
650010	Гэрээт ажилтан	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

#### **ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :**

Аудитаар нийт 998,230.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 310,834.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүйгээр ирсэн 32,360.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй,
- Тайлант онд зарцуулсан 71,104.2 мянган төгрөгийн шатах тослох материалыг бараа материалын тайланд үлдэгдлээр тусгасан,
- Өглөг 66,837.1 мянган төгрөгөөр дутуу,
- Үнэ төлбөргүйгээр ирсэн 406,285.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй,
- Акталсан 38,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй орхигдуулсан,
- Хөрөнгийн тайлант хуримтлагдсан элэгдлийг 166,463.1 мянган төгрөгөөр дутуу,
- Тайлант үеийн үр дүнг 56,899.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 160,280.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 160,280.8 мянган төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 4,354.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, албан шаардлага, 155,926.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

**5.1.1 Албан хаагчдын цалингийн шатлалыг зөрүүтэй тооцон 1,448.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон, өвс тэжээлийн үнэ 366.0 мянган төгрөгийг байгууллагын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

**5.1.2** Засаг даргын нөөц хөрөнгөнөөс урлагийн тоглолтод хандив өгсөн, ИТХ-ын төлөөлөгч нар урамшуулал буюу бэлэг дурсгалын зүйлд худалдан авахад нийт 2,540.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралтаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1-д “ Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна.”; 4.3-д “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээний санхүүжилтийг эхний ээлжид нөөц хөрөнгөөс гаргана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

## **5.2 Албан шаардлага**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.2.1 Тайлан гаргах, анхан шатны баримтын бүрдүүлэлт холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын 2024 оны жилийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, байгууллагын санхүүгийн баримтад зарлагын ажил гүйлгээний анхан шатны баримтууд нь эх хувиар нь хавсаргаагүй, сар бүр цалин бодож олгосон тухайн сард ажилласан эсэхийг нотлох цагийн бүртгэл, цалингийн тооцооны хүснэгт, цалинтай холбоотой гаргасан тушаал шийдвэр зэрэг анхан шатны баримтгүй цалингийн ажил гүйлгээ гаргасан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх; 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрддөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан шаардлага өгөө

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.3.1 Нийгмийн даатгалын тайлан гаргалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: НДШ-ийн 2024 оны 3 сарын тайланд 1 даатгуулагчийн мэдээллийг оруулаагүй, 2024 оны 8 сараас жирэмсэн амаржсаны тэтгэмжтэй 1 даатгуулагчийн төрлийг буруу сонгон шимтгэлийн тайлан илгээсэн нь Төсвийн тухай хуулийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-д “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;” гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2024 оны 03 дугаар сар, 8-12 сарын шимтгэлийн тайланд залруулга хийж тайланг нөхөн илгээх

### **5.3.2 Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын ойн хандивын хөрөнгөөр худалдан авсан 150 ширхэг сандлыг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого"; гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хандивын эх үүсвэрээр худалдан авсан хөрөнгийг орлогод авч данс бүртгэлд тусгах

### **5.3.3 Шатахууны зарцуулалт, тооцоо бодолт, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугаарлаагүй, жолоочийн замын хуудсанд спидометрийн заалт бичээгүй, зарим ажилд шатахуун давхардуулан олгодог, замын хуудсанд албан тушаалтнаар гарын үсэг зуруулаагүй жолооч нь өөрөө гарын үсэг зурсан, тайлант онд худалдан авсан 56,795.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй, зарцуулалтад дотоод хяналтгүй хэрэгжүүлээгүй, жолоочийн тооцоо бодоогүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны олгох бичгийг оны эхнээс дугаарлах, спидометрийн заалтыг үндэслэн сар бүр жолоочийн тооцоог бодож хэвших, шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

### **5.3.4 Бэлэн мөнгөний тооцоо бодолт, зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хариуцагчийн дансаар дамжуулан 93,239.4 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээний гарган зарцуулсан, бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй, тооцоо бодоогүй, анхан шатны баримтууд дутуу бүрдүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтын нөхөх заавар”-ын 3-д “бэлэн мөнгөн гүйлгээний тайлан НХМАягт МХ-4 “Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөний гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ. Нягтлан бодогч бэлэн мөнгөний тайлангийн хуудсыг нь хосоор ижил

дугаарлаж няравт өгөх бөгөөд тэрхүү дугаарын тоо санхүүгийн жилд тасралтгүй мөрдөгдөж байвал зохионо” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд няравын дансаар дамжуулан гаргасан бэлэн мөнгөний тайлан гарган тооцоог бодох, анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлэх,

### **5.3.5 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын 100 жилийн арга хэмжээний урилга, бусад зардлыг санхүүжүүлсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах

### **5.3.6 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээ, дараа жилийн төсвийн төсөл, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, байгууллагын батлагдсан төсөв, хандив, тусламжийн орлого, зарцуулалтын тайланг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.3.5-д “ хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”, “6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын ЗДТГазар	6	837,949.6	4	208,301.7	2	629,647.9	6	837,949.6	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>837,949.6</b>	<b>4</b>	<b>208,302</b>	<b>2</b>	<b>629,647.9</b>	<b>6</b>	<b>837,949.6</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шийжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай сумын ЗДТГазар	10	160,280.8	2	4,354.2	1	-	7	155,926.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>160,280.8</b>	<b>2</b>	<b>4,354.2</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>155,926.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	-	1	-	-
<b>НИЙТ</b>			1	-	-	-	-	-	-